

БАТЛАВ  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

2026 оны ... дугаар сарын ...

**“ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ” -ЫН  
2026-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

“Хот тохижилтын газар ОНӨААТҮГ”  
..... дарга

Г.Ууганбаяр

Улаанбаатар хот,  
2026 он

## АГУУЛГА

НЭГ.Нийтлэг үндэслэл

ХОЁР.Мандатын шинжилгээ

ГУРАВ.Алсын хараа

ДӨРӨВ.Эрхэм зорилго

ТАВ.Үнэт зүйлс

ЗУРГАА.Орчны шинжилгээ

ДОЛОО.Стратеги зорилго

НАЙМ.Байгууллагын стратеги төлөвлөгөө

ЕС.Хавсралт

## **Нэг. Нийтлэг үндэслэл**

Улаанбаатар хотын тулгамдсан асуудлуудын нэг хог хаягдлын менежментийг хэрхэн сайжруулах, нийслэлийн тохижилтыг дэлхийн хотуудын жишигт хэрхэн хүргэх, хог хаягдлын удирдлага, зохион байгуулалтын шинэчлэлтийн талаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга, нийслэл, дүүргийн төр захиргааны байгууллагуудаас анхаарал хандуулан тодорхой ажлуудыг хийж зохион байгуулж ирсний үр дүнд 2006 оны 09 дүгээр сард Монгол Улсын Засгийн Газрын 196 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 205 дугаар тогтоолыг үндэслэн Нийслэлийн Засаг даргын 445 дугаар захирамжаар Улаанбаатар хотын Захирагчийн харъяанд “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-ыг байгуулсан.

2007 онд Нийслэлийн ИТХТ-ийн 107 тогтоолоор “Нөөц” НӨҮГ-ыг татан буулгаж, үйл ажиллагааг нь хариуцуулсан болно.

Хот тохижилтын газар нь Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, төвлөрсөн хогийн цэгүүдэд хог хаягдлыг технологийн дагуу хөрсөөр дарж булах, нийтийн эзэмшлийн гудамж, автозам, явган зам, талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, тохижилт, хариуцсан гудамж зам талбайн хөшөө дурсгалын арчлалт хамгаалалт, эзэнгүй нохой муурын сэг зэмийг дарж булах, устгалд оруулах зэрэг үндсэн чиг үүрэг бүхий орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар юм.

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна” хэмээн заасан. Үүний дагуу Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам” болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 100 дугаар тушаалаар шинэчлэгдсэн “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-д нийцүүлэн стратеги төлөвлөгөөг боловсруулж, нийслэл хотын оршин суугчдын ажиллаж, аж төрөх таатай орчин нөхцөл бий болгоход орших бөгөөд үүнтэй уялдуулан Хот тохижилтын газрын нийтийн үйлчилгээг дэлхийн бусад улс орон, шинжлэх ухаан, технологийн хөгжил, дэвшилд ойртуулан орчин үеийн мэргэжлийн байгууллага болгон хөгжүүлэх асуудлыг стратеги, төлөвлөлттэйгээр хэрэгжүүлэх, илүү үр дүнтэй ажиллахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөв.

Хот тохижилтын газрын стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, 2024 оны 24/08 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн холбогдох заалтуудыг хэрэгжилтийг хангах зорилгоор тус газрын стратеги төлөвлөгөөг боловсруулав.

## Хоёр. Мандатын шинжилгээ

Хот тохижилтын газар нь Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Монгол улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, тухайн жилийн нийгэм, эдийн засгийн зорилт, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллана.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 14 тоот тогтоолоор газрын дүрмийг баталж дараах үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар тусгасан. Үүнд:

- Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ
- Төвлөрсөн хогийн цэгүүдийн үйл ажиллагаа
- Алтан-Өлгийн оршуулгын газрын арчлалт хамгаалалт
- Эзэнгүй нохой муурын устгал зэрэг ажлуудыг хариуцан ажиллана.

### Хүснэгт 1. Мандатын шинжилгээ

|                                                                                                                                                                                                        |                       |                                                                                                                                                                                                     |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа нийт хууль                                                                                                                                                   |                       | 10/арав/                                                                                                                                                                                            |
| Үүнээс:                                                                                                                                                                                                | Тухайн салбарын хууль | 1/нэг/                                                                                                                                                                                              |
|                                                                                                                                                                                                        | Нийтлэг мөрддөг хууль | 9/ес/                                                                                                                                                                                               |
| Ерөнхий чиг үүргийн хүрээнд: Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 14 дүгээр тогтоолоор баталсан чиг үүргүүд                                                                |                       |                                                                                                                                                                                                     |
| Үндсэн чиг үүрэг                                                                                                                                                                                       |                       | Дэд чиг үүрэг                                                                                                                                                                                       |
| 1. Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайг угаах, цэвэрлэх, хог хаягдлыг цуглуулж ачиж тээвэрлэх                                                                                                          |                       | 1.1 Нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцах                                                                                                                                 |
|                                                                                                                                                                                                        |                       | 1.2 Хариуцсан гудамж, зам талбайн хөшөө дурсгал, хайс хашлагыг угааж цэвэрлэх                                                                                                                       |
|                                                                                                                                                                                                        |                       | 1.3 Өвлийн улиралд хариуцсан гудамж, зам талбайн цас мөсийг цэвэрлэж, халтиргаа гулгааг арилгах                                                                                                     |
|                                                                                                                                                                                                        |                       | 1.4 Хариуцсан гудамж, зам талбайн цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг цуглуулж ачиж тээвэрлэх                                                                                                        |
| 2. Төвлөрсөн хогийн цэгүүдийн үйл ажиллагааг эрхлэх ба хог хаягдлыг хөрсөөр дарж булах, ариутгах, халдваргүйжүүлэх                                                                                     |                       | 2.1 Нийслэлийн 6 дүүргийн аж ахуйн нэгж албан байгууллага, иргэд болон нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгүүдэд 24 цагийн турш хүлээн авах |
| Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид                                                                                                                                                              |                       |                                                                                                                                                                                                     |
| Нийслэлийн засаг даргын тамгын газар болон Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын газар, Орчны бохирдол, хог хаягдлын, удирдлагын хэлтэс, төрийн бус байгууллага |                       |                                                                                                                                                                                                     |

|                                                               |                                                                                                                     |  |
|---------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------|--|
|                                                               | 2.2 Ландфилл технологийн дагуу хөрсөөр хучиж дарж булах                                                             |  |
| 3. Эзэнгүй нохой муурын устгасан сэг зэмийг дарж булах        | 3.1 Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт Нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд устгасан нохой муурын сэг зэмийг дарж булах |  |
| 4. Алтан-Өлгий оршуулгын газрын арчлалт хамгаалалтыг хариуцах | 4.1 Алтан-Өлгий оршуулгын газрын арчлалт, харуул хамгаалалтыг хариуцан ажиллах                                      |  |

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын чиг үүргийг холбогдох хууль, тогтоомжид тулгуурлан тодорхойлсон. Энэ хүрээнд Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ыг суурь болгон үзвэл дараах байдлаар гарч ирнэ:

1. Бодлого боловсруулах: Үндэсний хэмжээний болон салбар, орон нутгийн урт, дунд, богино хугацааны стратеги зорилт боловсруулах, төлөвлөх, хууль тогтоомжийн төсөл, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандарт тогтоох, бодлогын хэрэгжилтийн үнэлгээ хийх чиглэлээрх Засгийн газар, яамд болон нутгийн удирдлагын байгууллагуудын эрх хэмжээ хамаарна.

2. Зохицуулалт хийх: Тодорхой үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр төрийн байгууллагаас зөвшөөрөл, лиценз, магадлан итгэмжлэх, гэрчилгээ олгох зэрэг эрх хэмжээ хамаарна.

3. Зохион байгуулах: Тухайн шатны төрийн байгууллагад хуулиар тогтоож өгсөн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг удирдан чиглүүлэх эрх хэмжээ хамаарна.

4. Санхүүжилт: Төрийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллагуудын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, санхүүгийн дэмжлэг, зардал, хөрөнгө оруулалттай холбоотой эрх хэмжээ хамаарна.

5. Хүний нөөцийн бодлого: Удирдах албан тушаалтан болон албан хаагчдыг томилох, чөлөөлөх, чадавхижуулах, бэлтгэх, давтан сургах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх зэрэг эрх хэмжээ хамаарна.

6. Хяналт шинжилгээ, үнэлгээ: Төрийн байгууллагын дэвшүүлсэн зорилт, түүний хэрэгжилт, хүрсэн үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэх, ажлын чанар, гүйцэтгэлд хяналт шалгалт болон дотоод аудит хийх эрх хэмжээ хамаарна.

7. Үйлчилгээ үзүүлэх: Төрөөс үзүүлэх үйлчилгээг төрийн байгууллага болон нутгийн удирдлагын байгууллага, эсхүл гэрээний үндсэн дээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх эрх хэмжээ хамаарна.

Хүснэгт 2. Чиг үүрэг, эрх хэмжээ


| № | Чиг үүрэг | Захиргааны хэм хэмжээ |
|---|-----------|-----------------------|
|---|-----------|-----------------------|

|   |                                                                                                                 | Бодлого<br>боловсруулах | Зохицуулалт<br>хийх | Зохион<br>байгуулах | Санхүүжилт | Хүний нөөцийн<br>бодлого | Хяналт, үнэлгээ<br>хийх | Үйлчилгээ<br>үзүүлэх |
|---|-----------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|---------------------|---------------------|------------|--------------------------|-------------------------|----------------------|
| 1 | Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайг угаах, цэвэрлэх, хог хаягдлыг цуглуулж ачиж тээвэрлэх                      |                         |                     | *                   | *          | *                        | *                       |                      |
| 2 | Төвлөрсөн хогийн цэгүүдийн үйл ажиллагааг эрхлэх ба хог хаягдлыг хөрсөөр дарж булах, ариутгах, халдваргүйжүүлэх | *                       |                     | *                   | *          | *                        | *                       | *                    |
| 3 | Эзэнгүй нохой муурын устгасан сэг зэмийг дарж булах                                                             | *                       |                     | *                   | *          | *                        | *                       |                      |
| 4 | Алтан-Өлгий оршуулгын газрын арчлалт хамгаалалтыг хариуцах                                                      | *                       | *                   | *                   | *          | *                        | *                       | *                    |

Холбогдогч талуудыг тодорхойлохдоо Нийслэлийн Бодлогын судалгаа, шинжилгээний төвийн бусад байгууллагатай харилцах эрх хэмжээг үндэслэв.

Зураг 1. Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд холбогдогч талууд

#### Газрын үйл ажиллагаанд холбогдогч талууд



Эдгээр холбогдогч талуудын оролцоог мэдээлэх, зөвлөх, санал өгөх, хамтран ажиллах, шийдвэр гаргах гэсэн ерөнхий ангиллын хүрээнд тодорхойлсон болно. Хот тохижилтын газар ОНӨААТҮГ нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхдээ эдгээр холбогдогч талуудтай харилцах бөгөөд холбогдогч талууд өөрт хамаарах эрх хэмжээний хүрээнд тодорхой үүрэг оролцоотойгоор хамтран ажиллана.

### Хүснэгт 3. Холбогдогч талуудын оролцоо

| Холбогдогч талууд                             | Оролцоо  |                                 |            |                 |                |              |
|-----------------------------------------------|----------|---------------------------------|------------|-----------------|----------------|--------------|
|                                               | Мэдээлэх | Зөвлөх, эргэх холбоогоор хангах | Санал өгөх | Хамтран ажиллах | Шийдвэр гаргах | Хяналт тавих |
|                                               |          |                                 |            |                 |                |              |
| Нийслэлийн Засаг даргын тамгын газар          | *        | *                               | *          | *               | *              | *            |
| Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба      | *        | *                               | *          | *               | *              | *            |
| Засгийн газар                                 | *        | *                               |            |                 |                |              |
| Дүүргийн засаг даргын тамгын газар            | *        | *                               | *          | *               |                | *            |
| Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд | *        | *                               |            | *               |                |              |
| Нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагууд           | *        | *                               | *          | *               |                | *            |
| Төрийн бус байгууллагууд                      | *        | *                               | *          | *               |                | *            |
| Аж ахуйн нэгж байгууллагууд                   | *        | *                               | *          | *               |                |              |
| Хэвлэл мэдээллийн байгууллагууд               | *        | *                               |            | *               |                |              |

Чиг үүргийн хэрэгжилтийн талаарх үнэлгээг гаргахдаа Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын ажилтнууд болон холбогдох талуудын дунд явуулсан санал асуулгын үр дүнд тулгуурласан.

### Хүснэгт 4. Чиг үүргийн хэрэгжилт

| № | Чиг үүрэг                                                                                  | Албан хаагчдын үнэлгээ | Холбогдогч талуудын үнэлгээ | Дундаж хувь |
|---|--------------------------------------------------------------------------------------------|------------------------|-----------------------------|-------------|
| 1 | Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайг угаах, цэвэрлэх, хог хаягдлыг цуглуулж ачиж тээвэрлэх | 85.7%                  | 90.75%                      | 88.2%       |

|     |                                                                                                                 |       |       |        |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------------------------|-------|-------|--------|
| 2   | Төвлөрсөн хогийн цэгүүдийн үйл ажиллагааг эрхлэх ба хог хаягдлыг хөрсөөр дарж булах, ариутгах, халдваргүйжүүлэх | 71.4% | 80.5% | 75.95% |
| Уц[ | Эзэнгүй нохой муурын устгасан сэг зэмийг дарж булах                                                             | 78.6% | 75.5% | 77.05% |
| 4   | Алтан-Өлгий оршуулгын газрын арчлалт хамгаалалтыг хариуцах                                                      | 92.8% | 90%   | 91.4%  |

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын чиг үүргийн хэрэгжилтийг үнэлэхэд хамгийн өндөр хувьтай нь Алтан-Өлгий оршуулгын газрын арчлалт хамгаалалтыг хариуцах (92.8%), хамгийн бага үнэлгээтэй нь Төвлөрсөн хогийн цэгүүдийн үйл ажиллагааг эрхлэх ба хог хаягдлыг хөрсөөр дарж булах, ариутгах, халдваргүйжүүлэх (71.4%) байна. Төвлөрсөн хогийн цэгүүдэд хийгддэг Эзэнгүй нохой муурын устгасан сэг зэмийг дарж булах, Төвлөрсөн хогийн цэгүүдийн үйл ажиллагааг эрхлэх ба хог хаягдлыг хөрсөөр дарж булах, ариутгах, халдваргүйжүүлэх зэрэг ажлууд нь 80-аас доош хувь үнэлэгдсэн нь анхаарах шаардлагатайг харуулж байна. Нийт чиг үүргийн хүрээнд 70-аас доош хувьтай үнэлэгдсэн чиг үүрэг гарсангүй.

#### **Гурав. Алсын хараа**

Олон улсын жишигт хүрсэн хот нийтийн аж ахуйн үйлчилгээг нийслэлийн иргэдэд үзүүлнэ.

#### **Дөрөв. Эрхэм зорилго**

Нийслэл хотын иргэдийн ая тухтай, эрүүл орчинд амьдарч, ажиллах нөхцлийг хангаж, хотын өнгө төрхийг орчин үеийн өндөр түвшинд хүргэнэ.

#### **Тав. Үнэт зүйлс**

**Шударга, ил тод ажиллах.** Итгэлцэл дүүрэн, амжилттай хамтын ажиллагааны үндэс суурь бий болно.

**Хууль ёсыг мөрдөх.** Холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах

**Цэвэр аюулгүй орчин.** Нийслэл хотын иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх


**Ажлын бүтээмжийг дээшлүүлэх.** Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээнд ашиглагдах машин техникийн хүчин чадлыг нэмэгдүүлж, орчин үеийн тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх

#### **Зургаа. Орчны шинжилгээ**

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ нь:

- ❖ Захиргаа хүний нөөцийн хэлтэс
- ❖ Санхүү бүртгэлийн хэлтэс
- ❖ Дотоод хяналтын алба

- ❖ Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны алба
- ❖ Тохижилт үйлчилгээний алба
- ❖ Төвлөрсөн хогийн цэгүүдийн менежментийн алба
- ❖ Шуурхай үйлчилгээний алба
- ❖ Авто бааз гэсэн 8 нэгжтэй, 224 ажилтан албан хаагчидтай үйл ажиллагаагаа явуулж байна.



Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн чиг үүрэг:

1.Байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах түүнд тусгасан хэлтсийн чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлэх, хүний нөөцийн бодлогыг тодорхойлох, бусад хэлтэс, алба, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, үүрэг даалгаврын биелэлт, үйл ажиллагааны хагас, бүтэн жилийн тайланг дүгнэж, хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох газарт хугацаанд нь хүргүүлэх

2.Газрын бүтэц, орон тоог оновчтой төлөвлөх, хангах, хүний нөөцийн мэдээллийн сан бий болгох, ажилтан албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, сургалтыг зохион байгуулах, шагнал урамшууллын системийг бүрдүүлэх, Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт, үйл ажиллагаатай холбогдон гарах дүрэм журам, шийдвэрийн төслүүдийг боловсруулан батлуулах, хэлтэс албадад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавих

3.Газрын даргын зөвлөлийн шуурхай хурлыг зохион байгуулах, шуурхай хурлаар өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавих, үр дүнг тооцох, тайлагнах

4.Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэлтэс албадад мөрдүүлэх, заавар зөвлөгөөг өгч хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын бүхий л үйл ажиллагаанд хэвшүүлэх

5.Албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах эрх бүхий албан тушаалтныг бүртгэх, мэдээллийг гаргуулах, хадгалах, зааварчилгаа маягтын дагуу мэдээг хуулийн хугацаанд хянан гаргах

6.Ажилтан албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэх, эрүүл мэндийн үзлэгт хуваарийн дагуу хамруулах, ажилтан албан хаагчдыг хөдөлгөөний хомсдлоос сэргийлэх, хэлтэс албадын хоорондын нэгдмэл байдлыг хангах, багийн ажиллагааг бэхжүүлэх хүрээнд урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулах

7.Мэдээллийн ил тод байдлыг ханган иргэд, олон нийтэд өөрийн байгууллагын болон нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж буй ажлыг сурталчлах, мэдээлэх

8.Байгууллага, аж ахуй нэгжтэй байгуулах гэрээний үндэслэл, нөхцлийг хууль, дүрэм журам, стандартад нийцүүлэн боловсруулах, гэрээний биелэлтийг хангуулах

9.Газрын хэмжээнд өдөр тутмын болон цаг үеийн холбогдолтой дотоод зохион байгуулалтыг хийх, ажилтан албан хаагчдын болон ажлын байрны сахилга дэг журмыг дээшлүүлэх, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдүүлэх, байгууллагын эерэг соёлыг бүрдүүлж хэвшүүлэх, ажилтан албан хаагчдын ажлын гүйцэтгэл, хөдөлмөрийн бүтээмж, цаг ашиглалтад хяналт тавих, манлайллыг бий болгох.

10.Уулзалт, хурал зөвлөгөөн, бусад шуурхай хуралдааныг зохион байгуулах

11.Хэлтэс албадуудаас өдөр бүр шаардлагатай мэдээ мэдээлэл, тооцоо судалгааг авч удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангаж, хэлтэс, алба, нэгж хоорондын уялдаа холбоог сайжруулахад санал санаачлагатай ажиллах.

12.Газрын үндсэн үйл ажиллагаатай холбоотой иргэн, аж ахуйн нэгжээс 24 цагаар дуудлага хүлээн авах, мэдээлэх, өдөр тутмын ажлын мэдээ мэдээллийг холбогдох алба, нэгжээс авч нэгтгэх, холбогдох байгууллагуудад явуулах зэргээр байгууллагын үйл ажиллагааны уялдааг хангах, Нийслэлийн шуурхай удирдлагын нэгдсэн төвийг үнэн зөв мэдээллээр хангах

Санхүү, бүртгэлийн хэлтсийн чиг үүрэг:

1.Санхүүгийн бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, Монгол Улсын нягтлан бодох бүртгэл, Төсвийн тухай хууль, “Төрийн албаны тухай” хууль, “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай” хууль, “Хөдөлмөрийн тухай” хууль, “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай” хууль, “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хууль, “Аудитын тухай” хууль, “Төсвийн болон орон нутгийн тухай” хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хөтөлж тайлагнах

2.Газрын үндсэн чиглэл, стратеги төлөвлөлт, хот тохижилт, нийтийн үйлчилгээний хүрээнд Нийслэлийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, газрын алсын хараа, эрхэм зорилго, зорилт, холбогдох хууль тогтоомж, дотоод журамтай уялдуулан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан хэлтсийн үйл ажиллагаанд хамаарах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх

3.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудад нийцүүлэн боловсруулах

4.Газрын санхүүгийн дотоод болон гадаад тайлангуудыг үнэн зөв, цаг хугацаанд нь дүрэм, журам, хуульд нийцүүлэн боловсруулж гаргах

5.Хөтлөгдвөл зохих анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн маягтуудын загварыг баталж санхүүгийн програмаас гаргаж, салбар хэлтэс албадуудад жигд стандартчлагдсан байдлаар мөрдүүлэх

6.Жил, улирал, сарын мөнгөний урсгалыг төлөвлөж сар бүр шаардлагатай бол өөрчлөлт, зохицуулалт хийх

7.Хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажил төслийг /тохижилт, засвар, шинэчлэлийн ажил/ санхүүгийн программд бүртгэж, үнэн зөв капиталжуулах, урсгал засварт хяналт тавих

8.Санхүүгийн холбогдолтой тайлан мэдээг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох дээд байгууллагуудад илгээх

9.Үйлчилгээний орлого, төлбөр хураамж хүлээн авах ажлыг банкны дансаар гүйцэтгүүлэх үндсэн шаардлагуудыг банктai хамтран ажиллах гэрээнд тусгуулан мөрдүүлж хяналт тавих

10.Бараа материалын хадгалалт, хамгаалалтын ажлыг зохион байгуулах, үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд хийх, өмч хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, хяналт тавих

11.Улирлын тайлан тэнцлийн дүн шинжилгээг Газрын даргын дэргэдэх зөвлөлд танилцуулах

12.Хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм журмыг боловсруулж удирдлагад танилцуулж батлуулах

13.Санхүүгийн үргүй зардлыг багасгаж, үнийн бодлогод шинжилгээ, судалгаа хийж, хэмнэлттэй ажиллах

14.Хэлтэс, алба, нэгжийн зардалд хяналт тавьж, тухай бүр нь заавар, зөвлөгөө өгч авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар чиглэл өгөх

15.Холбогдох хууль журмын хүрээнд байгууллагын санхүүгийн мэдээллийг цахим системд бүртгэж, хэрэгжилтийг хангаж ажиллах

Дотоод хяналтын алба:

1. Газрын даргын шууд удирдлагад дор ажиллаж, стратеги төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан хэлтсийн хамаарах үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж, бусад хэлтэс, алба, нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаа, гүйцэтгэлийн төлөвлөгөө, үүрэг даалгаврын биелэлтэд дотоод хяналт, шалгалт, дүн шинжилгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангах.

2.Газрын хэлтэс, алба, нэгжийн чиг үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

3.Газрын өмч хөрөнгийн бүртгэл, хадгалалт хамгаалалт, ашиглалт, өмчлөлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалт явуулах

4.Газрын даргаас өгсөн чиглэл, удирдамжийн дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг явуулж, дүгнэлтийг удирдлагад танилцуулж ажиллах

5.Дотоод хяналтыг бие даасан, хараат бусаар хийж, дүгнэлт гаргахын зэрэгцээ шаардлагатай гэж үзвэл бусад хэлтэс алба, хөндлөнгийн болон хууль хяналтын байгууллагатай хамтран явуулах

6.Дотоод хяналтын ажлын явцад илэрч буй зөрчил доголдол, алдаа дутагдлыг арилгуулах, давтан гаргуулахгүй байх, эрсдлийг үнэлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, үйл ажиллагааг ил тод нээлттэй мэдээлэх, тайлагнаж ажиллах

7.Хэлтсийн үйл ажиллагааны онцлогт нийцсэн дотоод хяналт шалгалтын журам болон холбогдох журмыг боловсруулж мөрдөх

8.Газрын цахим бодлогыг хэрэгжүүлэх, компьютер хэрэгсэл, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, мэдээлэл холбоо, цахим программ, мэдээллийн сан, сүлжээний аюулгүй ажиллагааг хангаж, хяналт тавих

9.Хэлтэс албанаас холбогдох чиглэлээр шаардлагатай мэдээ тайлан, танилцуулга, судалгаа, үүрэг даалгаврын биелэлт, холбогдох лавлагаа, мэдээллийг гаргуулж авах

10.Хонхтой цэцэрлэгт хүрээлэнгийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, хэвийн үйл ажиллагааг хангах

Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны алба:

1.Газрын эдийн засгийн зорилтын үзүүлэлтийг нэгтгэн гаргаж Удирдах зөвлөлд танилцуулан батлуулж, хэрэгжилтийг хангах

2.Худалдан авах ажиллагааг жилийн төсөв, төлөвлөгөөний дагуу “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай” хуулийн дагуу зохион байгуулах

2.Хөрөнгө оруулалт, тохижилт бүтээн байгуулалтын ажлын тооцоо судалгаа, чиг үүргийн дагуу нэмэлтээр гүйцэтгэх ажлын тооцоог гарган ашиг орлогыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах

3.Чиг үүргийн дагуу гүйцэтгэж буй ажлын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, тайлан мэдээ, гүйцэтгэлийг тогтоосон хугацаанд гаргаж хэрэгжилтийг хангах

4.Төсвийн хөрөнгөөр авч буй хөрөнгө оруулалтын ажил болон бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулж, туслан гүйцэтгэгчтэй хамтран ажиллахад холбогдох хууль, эрх зүйн актыг мөрдлөг болгох.

5.Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын явц, үр дүнг газрын даргын зөвлөлд танилцуулж, тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх.

6.Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагын өмчлөлд шилжүүлэх ажлыг тухай бүр зохион байгуулах

Тохижилт үйлчилгээний албаны чиг үүрэг:

1.Байгууллагын стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан тус албаны хамаарах үйл ажиллагааг хэрэгжүүлж, төлөвлөгөөний биелэлтийг улирал тутам, үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр тайлагнаж, хэрэгжилтийг хангаж ажиллах

2.Хариуцсан зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх, үйл ажиллагаандаа шинэлэг менежмент дэвшилтэт шинэ арга хэлбэр, технологийг нэвтрүүлж ажиллах

3.Дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу хариуцаж буй замын цэвэрлэгээний ажлын гүйцэтгэлийг сар бүрийн 05-ны өдрийн дотор гаргаж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлэх

4.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг мөрдөж ажиллах, стандарт мөрдүүлэх ажлыг оновчтой байдлаар зохион байгуулж тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх ажлыг зохион байгуулах

5.Шаардлагатай онцгой тохиолдолд гудамж зам талбайн цэвэрлэгээг шуурхай хийж гүйцэтгэх

6.Алтан-Өлгий хүндэтгэлийн оршуулгын газрын үйл ажиллагааг хариуцан тогтмол хяналт тавьж ажиллах

7.Хог хаягдлын ачилт, тээвэрлэлтийг тухай бүр хийлгэж, гудамж зам талбайг хоггүй байлгах

8.Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө (хогийн сав, сандал, хөшөө дурсгал)-ийг арчиж цэвэрлэх

9.Зөөврийн био 00-ын ариун цэвэр, хангалт, үйлчилгээг тухай бүр хариуцан ажиллах

Төвлөрсөн хогийн цэгүүдийн менежментийн албаны чиг үүрэг:

1.Байгууллагын стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан тус албаны хамаарах үйл ажиллагааг хэрэгжүүлж, төлөвлөгөөний биелэлтийг улирал тутам, үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр тайлагнаж, хэрэгжилтийг хангаж ажиллах.

2.Хог хаягдлыг ландфилл технологийн дагуу хөрсөөр дарж булах ажлыг технологийн дагуу хийж гүйцэтгэх, галын эрсдлийг бууруулах

3.Хог хаягдлыг дарж булах, хөрсөөр хучиж эрүүлжүүлэх, халдваргүйжүүлэх ажлыг технологийн дагуу хийж гүйцэтгэх.

4.Хог тээвэрлэн ирж буй машиныг нэвтрүүлэхдээ хүний оролцоогүйгээр пүү, хог бүртгэлийн программын хэвийн ажиллагааг хангаж, бүртгэлжүүлэх.

5.Төвлөрсөн хогийн цэгүүдэд хог тээвэрлэн ирж байгаа тээврийн хэрэгсэл, хог хүлээн авах талбайг ариутгах ажлыг зохион байгуулах

6.Хоёрдогч түүхий эд цуглуулагч иргэд болон худалдан авагч иргэн, аж ахуй нэгжийг төвлөрсөн хогийн цэгүүд рүү нэвтрүүлэхгүй байх арга хэмжээ авч ажиллах  
Хог хаягдлын төлбөрийг тогтоосон тарифын дагуу иргэн, аж ахуйн нэгжүүдээс хураан авах.

7.Төвлөрсөн хогийн цэгүүдийн машин механизм, техник хэрэгсэлийн засвар үйлчилгээг тогтмол хийж, эвдрэл гэмтлийг засварлаж, бэлэн байдлыг хангаж ажиллах

8.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг мөрдөж ажиллах, стандарт мөрдүүлэх ажлыг оновчтой байдлаар зохион байгуулж тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх ажлыг зохион байгуулах

9.Төвлөрсөн хогийн цэгүүдийн талбайг тохижуулах, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаж, байгаль орчинд хог хаягдлаас үүсэх сөрөг нөлөөллийг багасгах.

10.Жолооч нар “Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ” байгуулж, хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг мөрдөж ажиллах.

Шуурхай үйлчилгээний албаны чиг үүрэг:

1.Байгууллагын стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан тус албаны хамаарах үйл ажиллагааг хэрэгжүүлж, төлөвлөгөөний биелэлтийг улирал тутам, үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр тайлагнаж, хэрэгжилтийг хангаж ажиллах.

2.Газрын өмч хөрөнгөтэй холбоотой засвар үйлчилгээ, тохижилтын ажил, эвдрэл гэмтэл, хайс хашлага, сандал, хогийн савны арчлалт хамгаалалтыг хариуцаж бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах.

3.Аваар ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцлийг хангаж ажиллах

4.Шуурхай удирдлагын цахим төв, хэлтэс, албадын захиалга, дуудлагыг хүлээн авч, шуурхай арга хэмжээ авч ажиллах.

Авто баазын чиг үүрэг

1.Байгууллагын стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан тус албаны хамаарах үйл ажиллагааг хэрэгжүүлж, төлөвлөгөөний биелэлтийг улирал тутам, үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр тайлагнаж, хэрэгжилтийг хангаж ажиллах.

2. Авто баазын хөдлөх бүрэлдэхүүний засвар үйлчилгээ, бүрэн бүтэн байдлыг хангаж машин техник, механизмын хувийн хэрэг хөтлөх

3.Автобааз нь хариуцсан гудамж зам талбайн цэвэрлэгээг зориулалтын автомашинаар цэвэрлэж, /шүүрдэх, соруулах/ зам талбайн үйлчлэгч нарын тодорхой цэгт цуглуулсан хог хаягдлыг цаг хугцаанд нь ачиж тээвэрлэх.

4.Өвлийн улиралд цас мөсийг цэвэрлэх, халтиргаа гулгаагүй болгох, зориулалтын тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллах

5.Жолооч нар “Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ” байгуулж, хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг мөрдөж ажиллах.

6.Авто баазын ажлын байрны эмх цэгц, цэвэр цэмцгэр байдлыг хангаж ажиллах

7.Байгууллагын гамшгаас хамгаалах нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, холбогдох байгууллагатай хамтран ажиллах, аюул ослоос урьдчилан сэргийлэх.

8.Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд хүн хүч, машин техникийн шуурхай зохицуулалт хийх, ослын үеийн, онцгой байдлын, гамшгийн үеийн мэдээ мэдээллийг холбогдох газарт мэдээллэх.

Стратегийг боловсруулахын тулд хуулийн хүрээнд тодорхойлогдсон чиг үүргээ хэрэгжүүлэх чадавхын өнөөгийн давуу, сул тал, орчны нөлөөллийн боломж, эрсдлийг илэрхийлэх гол хүчин зүйлсийг тус тус сонгож авсан болно.

| ДОТООД ОРЧИН                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Давуу тал:</b><br>1.Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээ хариуцдаг ажилчдын цалин өндөр. Цалин тогтмол хугацаандаа олгогддог.<br>2.Эрүүл мэндийн үзлэгт тогмол хамруулдаг.<br>3.Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, хотын цэвэрлэгээ, эрүүл ахуйд чухал хувь нэмэр оруулдаг.<br>4.Туршлагатай, ур чадвартай боловсон хүчинтэй. | <b>Сул тал:</b><br>1.Ажилчдыг мэргэшүүлэх сургалт хөгжлийн үйл ажиллагаа хангалтгүй<br>2.Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх оролцоо сул<br>3.Хөдөлмөрийн нөхцөл хүнд, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй<br>4.Төвлөрсөн хогийн цэгийн ажиллах орчин нөхцөл хүнд, орчны дуу чимээ, автомашины хорт утаа, тоосжилт, хорхой шавж маш их<br>5.Нийгэмд ажлын нэр хүнд, үнэлэмж доогуур, иргэдээс ирэх шүүлмжлэлд их өртдөг |

| <p>5.Ажилчин албан хаагчдын ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлсэн</p> <p>6.Машин техник бүрэн багтах том талбайтай дулаан гражтай</p> <p>7.Үйл ажиллагаанаас нэмэлт орлого олох боломжтой</p> <p>8.Сүүлийн үеийн техникуудээр парк шинэчлэлт хийгдсэн</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | <p>6.Цалингийн тэгш бус байдал</p> <p>7.Төвлөрсөн хогийн цэгүүдийн хашаа тусгаарлалт муу байдгаас хог түүгчид олноор амьдардаг</p> <p>8.Хогийн цэг гэрэлтүүлэггүй, сүлжээ, интернетгүйгээс үйл ажиллаанд тавих хяналт сул</p> <p>9.Төсвөөс хамаарал ихтэй тул шинэ төсөл хэрэгжүүлэхэд боломж дутмаг.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| ГАДААД ОРЧИН                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| <p><b>Боломж:</b></p> <p>1.Хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах олон улсын төсөл, хөтөлбөрийн дэмжлэг авах хэрэгжүүлэх боломжтой</p> <p>2.Дижитал хяналт, менежментийн систем нэвтрүүлэх боломжтой</p> <p>3.Тусгай зориулалтын шатаах цехтэй болох</p> <p>4.Ажилчдын ур чадварыг сайжруулах сургалт зохион байгуулах боломжтой</p> <p>5.Хогийн цэг гэрэлтүүлэг сайжруулах</p> <p>6.Хогийн цэгт нөхөн сэргээлт хийж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх боломжтой.</p> <p>7.Төсвийн санхүүжилтээс гадна цэвэрлэгээ, усалгаа, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил авч, нэмэлт орлого олох боломжтой</p> <p>8.Байгууллагын үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, олон нийтэд түгээн таниулснаар иргэдийн ухамсарт нөлөөлж, байгууллагын нэр хүнд, үнэлэмж сайжрах</p> <p>9.Хог хүлээн авах талбайн чиглүүлэгч, операторуудыг хүнд хортой нөхцөлд хамруулах</p> | <p><b>Эрсдэл:</b></p> <p>1.Хогийн цэгийн орчноос үүдэн халдварт өвчнөөр өвчлөх эрсдэл нэмэгдэх, нян бактери үржих эрсдэлтэй</p> <p>2.Хог хүлээн авах талбайд гэрэлтүүлэг байхгүйгээс үүдэн аваар осол гарах эрсдэлтэй</p> <p>3.Тэтгэвэрийн нас нэмэгдсэнтэй холбоотойгоор хортой нөхцөлд ажиллаж буй өндөр настай хүмүүс ажиллах чадамж сулрах.</p> <p>4.Хогийн цэгт хашаажуулалт, харуул хамгаалалт муугаас ээлжийн ажилчид хулгайн гэмт хэрэг, халдлагад өртөх, хог түүгч нарын амь нас хохирох эрсдэлтэй</p> <p>5.Хүн амын төвлөрөл ихэсч байгаагаас хамаарч жил ирэх тусам хог хаягдлын хэмжээ нэмэгдэж, хог хүлээн авах талбайн нөөцгүй болох эрсдэлтэй</p> <p>6.Хогийн цэгүүдэд ирсэн хог хаягдлыг ангилж ялгаагүйн үүднээс байгаль орчин, эко систем алдагдах эрсдэлтэй</p> <p>7.Иргэдийн ухамсар, оролцоо дутмагаас ажилчдын ажиллах идэвх, урам зориг буурах эрсдэлтэй</p> <p>8.Хувийн хэвшлийн өрсөлдөөн</p> |

**SWOT** шинжилгээ нь байгууллагын дотоод давуу болон сул тал гадаад орчны боломж ба эрсдэлийг илрүүлэн тодорхойлох стратегийн чухал хэрэгсэл юм. Хот тохижилтын газрын ажилчдаас судалгаа авч нэгтгэн **SWOT** шинжилгээ хийлээ. Шинжилгээнээс харахад хот нийтийн аж ахуйн салбарын машин техникт парк шинэчлэлт хийдсэнээр ажлын бүтээмж нэмэгдэж, нэмэлт орлого /цэвэрлэгээ, усалгаа, тохижилт буулгалтын ажил/ олох

бүрэн боломжтой болж байна. Ингэснээр төвлөрсөн хогийн цэгүүдийн ажилчдын ажиллах нөхцөл боломж сайжирч, ажиллах орчинд үүсэх эрсдэл буурах юм.

Гадаад орчны хувьд SWOT шинжилгээг баяжуулан PESTLE шинжилгээ давхар хийх замаар тодорхойллоо.

| Үзүүлэлт    | Хамаарах гол эерэг, сөрөг хүчин зүйлс                                                                                                                                                                                                       | Нэмэлт тайлбар                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
|-------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Улс төр     | <ul style="list-style-type: none"> <li>- Улс төрийн тогтворгүй байдал</li> <li>- Чиг үүргийн тодорхойгүй байдал</li> <li>- ОНӨААТҮГ учир ашиг олох боломжтой</li> </ul>                                                                     | Тус газар нь Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанд харьяалагддаг тул хотын удирдлага солигдох, бодлогын өөрчлөлтөөс шалтгаалан бүтэц, чиг үүрэг өөрчлөгдөх, санхүүжилт тасрах зэрэг улс төрийн эрсдэлтэй. Төсвийн санхүүжилтээс гадна цэвэрлэгээ, усалгаа, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил авч, нэмэлт орлого олох боломжтойб                                                     |
| Эдийн засаг | <ul style="list-style-type: none"> <li>- Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээ хариуцдаг ажилчдын цалин өндөр</li> <li>- Цалингийн тэгш бус байдал</li> <li>- Төсвийн хамаарал их</li> <li>- Хувийн хэвшлийн өрсөлдөөн</li> </ul> | Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээ хариуцдаг ажилчдын цалин өндөр ч бусад ажилчдын цалин бүтээмжтэй харьцуулахад бага. Төсвөөс хамаарал ихтэй тул шинэ төсөл хэрэгжүүлэх боломж дутмаг хэдий ч төсвийн санхүүжилтээс гадна цэвэрлэгээ, усалгаа, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил авч, нэмэлт орлого олох боломжтой                                                         |
| Нийгэм      | <ul style="list-style-type: none"> <li>- Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх оролцоо сул</li> <li>- Хөдөлмөрийн нөхцөл хүнд, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй</li> <li>- Олон нийтийн хандлага сөрөг</li> </ul>                                | Байгууллагын үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, олон нийтэд түгээн таниулснаар иргэдийн ухамсарт нөлөөлж, байгууллагын нэр хүнд, үнэлэмж сайжирснаар ажилчдын идэвх, урам зориг нэмэгдэх боломжтой. Хог хүлээн авах талбайн чиглүүлэгч, операторуудыг хүнд хортой нөхцөлд хамруулах шаардлагатай. Төвлөрсөн хогийн цэгт хашаажуулалт, харуул хамгаалалт муугаас ээлжийн ажилчид хулгайн гэмт хэрэг, |

|                      |                                                                                                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
|----------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                      |                                                                                                                                                                                                     | халдлагад өртөх, хог түүгч нарын амь нас хохирох эрсдэлтэй                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
| <b>Технологи</b>     | <ul style="list-style-type: none"> <li>- Сүүлийн үеийн техникүүдээр парк шинэчлэлт хийгдсэн</li> <li>- Хогийн цэг гэрэлтүүлэггүй, сүлжээ, интернетгүйгээс үйл ажиллаанд тавих хяналт сул</li> </ul> | Тусгай зориулалтын техникийг үйл ажиллагаандаа ашиглан хүний хөдөлмөрийг хөнгөвчилсөн. Хогийн цэгт хашаажуулалт, харуул хамгаалалт, гэрэлтүүдэг муугаас ээлжийн ажилчид хулгайн гэмт хэрэг, халдлагад өртөх, хог түүгч нарын амь нас хохирох эрсдэлтэй                                                                                                                                                                                        |
| <b>Хууль эрх зүй</b> | <ul style="list-style-type: none"> <li>- Үйл ажиллагаа нь хог хаягдлын тухай хуулиар баталгаажсан</li> </ul>                                                                                        | Энгийн хог хаягдлыг хөрсөөр дарж булах тариф, нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээний тариф хуулиар баталгаажсан                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| <b>Байгаль орчин</b> | <ul style="list-style-type: none"> <li>- Төвлөрсөн хогийн цэгийн орчин нөхцөл хүнд</li> </ul>                                                                                                       | Төвлөрсөн хогийн цэгийн ажиллах орчин нөхцөл хүнд, орчны дуу чимээ, автомашины хорт утаа, тоосжилт, хорхой шавж маш ихээс үүдэн халдварт өвчнөөр өвчлөх эрсдэл нэмэгдэх, нян бактери үржих эрсдэлтэй. Хүн амын төвлөрөл ихэсч байгаагаас хамаарч жил ирэх тусам хог хаягдлын хэмжээ нэмэгдэж, хог хулээн авах талбайн нөөцгүй болох, хогийн цэгүүдэд ирсэн хог хаягдлыг ангилж ялгаагүйн үүднээс байгаль орчин, эко систем алдагдах эрсдэлтэй |

### Долоо. Стратегийн зорилго

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2026-2028 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хүрээнд тус газрын чиг үүргийн ажилтай хамаарал бүхий арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Стратегийн хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Байгууллагын соёл ба манлайлал
  - Удирдах ажилтнуудын манлайллын ур чадвар, ёс зүйн стандартыг шинэчлэх, тогтмол сургалт, хөгжлийн хөтөлбөрөөр дэмжих.
  - Дотоод харилцаа, хамтын шийдвэр гаргалтыг дэмжих механизм нэвтрүүлэх.

- Ажилтнуудын ажлын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, дотоод уур амьсгалыг эерэг болгох зорилгоор зохион байгуулалтын орчныг шинэчлэх (багийн ажил, сэтгэл зүй, ажлын ачаалал хуваарилалт, карьер төлөвлөлт гэх мэт).

## 2. Оролцогч талуудын оролцоо

- Иргэд, хувийн хэвшил, ТББ, ажилтнууд зэрэг оролцогч талуудын оролцоог системтэй хангах нээлттэй мэдээллийн систем, санал авах, хэлэлцэх, саналд хариу өгөх тогтолцоог бүрдүүлэх.

## 3. Гүйцэтгэл ба өөрчлөлтийг удирдах

- Байгууллагын өөрийн үнэлгээ, гүйцэтгэлийн дүн шинжилгээний тогтолцоог ажилтны оролцоотойгоор хэрэгжүүлж, сайжруулалтын арга хэрэгслийн судалгаа хийх

## 4. Оролцогч талуудын сэтгэл ханамж, ойлголт

- Иргэд, ажилтан, бизнес эрхлэгчид зэрэг гол оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааг жил бүр тогтмол авах.

- Судалгааны дүнг байгууллагын удирдлага, хамт олонд танилцуулж, сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх.

- Иргэдийн санал гомдлыг авах, шийдвэрлэх процессыг цахим, уламжлалт хэлбэрээр хүртээмжтэй болгох, хариу арга хэмжээг ойлгомжтой мэдээлж байх.

- Сэтгэл ханамжид эерэгээр нөлөөлөх шинэ санаачилгыг дэмжиж, нийтэд түгээх.

## 5. Стратегийн болон үйл ажиллагааны гүйцэтгэл

- Амжилт, үр дүнд тулгуурласан урамшуулал, хариуцлагын системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх.

- Гүйцэтгэлийн үзүүлэлтүүдэд тулгуурлан байгууллагуудын харьцуулалт, шилдэг туршлагын солилцооны тогтолцоо бий болгох.

Эдгээр зөвлөмжүүдийг стратеги төлөвлөгөөндөө тусгаснаар байгууллагын засаглалын шинэчлэлийн зорилго тодорхой үр дүнд хүрч, иргэдийн итгэл, оролцоог нэмэгдүүлэн, тогтвортой, тасралтгүй сайжруулалтад чиглэсэн сайн засаглалын шинэ тогтолцоог бий болгох суурь тавигдах юм.

## **Найм. Стратегийн зорилго ба бүтцийн уялдаа холбоо**

Тус газрын стратеги төлөвлөгөөний 4 зорилгыг зохион байгуулалтын хэлтэс, албадууд үндсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлнэ.

1.Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, хотын өнгө үзэмжийг сайжруулах гэсэн зорилгыг Тохижилт үйлчилгээний алба, Авто бааз, Шуурхай үйлчилгээний албадууд хариуцан хэрэгжүүлнэ.

2.Ажилчдын ажиллах орчин нөхцөл, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж сайжруулах зорилгыг Захиргаа хүний нөөцийн хэлтэс, Санхүү бүртгэлийн хэлтэс, Хөрөнгө оруулалт худалдан авах ажиллагааны алба хариуцан хэрэгжүүлнэ.

3 Төвлөрсөн хогийн цэгүүдийн менежментийн алба болон авто баазын зарим ажилтан албан хаагчдыг хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад оруулах бэлтгэл ажлыг хангах гэсэн зорилгыг Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтарч Захиргаа хүний нөөцийн хэлтэс, Төвлөрсөн хогийн цэгүүдийн менежментийн алба хариуцан хэрэгжүүлнэ.

4.Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг олон нийтэд ил тодоор мэдээлэх, иргэдийн ухамсарт эерэг нөлөөлөл үзүүлэх зорилгыг Захиргаа хүний нөөцийн хэлтэс хариуцан гүйцэтгэнэ.

Дээрхи зорилгуудын хэрэгжилтийг ханган ажиллахад бусад чиг үүргийн хэлтэс албадууд хамтарж ажиллана.

**Найм. 2026-2028 оны СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2026 оны 01 дүгээр сарын 10

| <b>Д/д</b> | <b>Зорилт</b>                                                                                 | <b>Хэрэгжүүлэх арга зам</b>                                                                        | <b>Шалгуур үзүүлэлт</b> | <b>Суурь түвшин</b> | <b>Зорилт от түвшин</b> | <b>Санхүүгийн эх үүсвэр</b> |
|------------|-----------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|---------------------|-------------------------|-----------------------------|
| 1.         | Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, хотын өнгө үзэмжийг сайжруулах      | Хариуцсан гудамж зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээнд орчин үеийн техникийг нэвтрүүлэх судалгаа хийх | Дүн шинжилгээ           | -                   | 1                       | Нийслэлийн төсөв            |
| 2          |                                                                                               | Зам цэвэрлэгээний тусгай зориулалтын машин техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх                      | Тоо хэмжээ              | 1                   | 2                       | Нийслэлийн төсөв            |
| 3          |                                                                                               | Ариутгал халдваргүйжүүлэлт хийх давтамжийг нэмэгдүүлэх                                             | Давтамжийн тоо          | 2                   | 4                       | Нийслэлийн төсөв            |
| 4          | Ажилчдын ажиллах орчин нөхцөл, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж сайжруулах                   | 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгах                                             | Гүйцэтгэлийн хувь       | 100                 | 100                     | Байгууллагын хөрөнгө        |
| 5          |                                                                                               | Ажлын байрны тохижилтыг сайжруулах ажлын хүрээнд амрах байранд засвар үйлчилгээ хийх               | Гүйцэтгэлийн хувь       | 50                  | 100                     |                             |
| 6          |                                                                                               | Компьютер техник тоног төхөөрөмжийг шинэчлэх                                                       | Тоо хэмжээ              | -                   | 3                       | Нийслэлийн төсөв            |
| 7          |                                                                                               | Ажилтан албан хаагчдыг сургаж мэргэжшүүлэх                                                         | Давтамжийн тоо          | 2                   | 4                       | Байгууллагын хөрөнгө        |
| 8          | Төвлөрсөн хогийн цэгүүдийн менежментийн алба болон авто баазын зарим ажилтан                  | Газрын ажилчдын Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтарч ажиллах                                      | Гүйцэтгэлийн хувь       | 100                 | 100                     | Байгууллагын хөрөнгө        |
| 9          | албан хаагчдыг хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад оруулах бэлтгэл ажлыг хангах | Мэргэжлийн байгууллагаар ажлын байрны судалгаа, зураг авалт хийх                                   | Гүйцэтгэлийн хувь       | 100                 | 100                     | Байгууллагын хөрөнгө        |

|    |                                                                                                                  |                                                                                                               |                         |           |     |                      |
|----|------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|-----------|-----|----------------------|
| 10 |                                                                                                                  | Мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулах                                             |                         |           |     |                      |
| 11 | Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг олон нийтэд ил тодоор мэдээлэх, иргэдийн ухамсарт эерэг нөлөөлөл үзүүлэх | Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч ажиллаж, үйл ажиллагааг сурталчлах таниулах                        | Байгууллагын тоо        | -         | 5   | Байгууллагын хөрөнгө |
| 12 |                                                                                                                  | Хог хаягдлын талаар иргэдийн ухамсарт нөлөөлөх нөлөөллийн ажил, арга хэмжээ зохион байгуулах                  | Ажлын тоо               | 1         | 4   | Байгууллагын хөрөнгө |
| 13 | Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайг угаах, цэвэрлэх, хог хаягдлыг цуглуулж ачиж тээвэрлэх                       | Хариуцсан гудамж зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээнд хүний хөдөлмөрийг хөнгөвчилсөн тоног төхөөрөмж нэвтрүүлэх | Тоо хэмжээ              | 3         | 5   | Байгууллагын хөрөнгө |
| 14 |                                                                                                                  | Авто зам болон явган замын цас мөс, халтиргаа гулгааг арилгах                                                 | Замын тоо хэмжээ /км/   | 18        | -   | Байгууллагын хөрөнгө |
| 15 | Төвлөрсөн хогийн цэгүүдийн үйл ажиллагааг эрхлэх ба хог хаягдлыг хөрсөөр дарж булах, ариутгах, халдваргүйжүүлэх  | Төвлөрсөн хогийн цэгүүдэд ирж буй хог хаягдлыг ландфилл технологийн дагуу хөрсөөр дарж булах                  | Ирсэн хогны хэмжээ /тн/ | 1,700,000 | -   | Нийслэлийн төсөв     |
| 16 | Алтан-Өлгий оршуулгын газрын арчлалт хамгаалалтыг хариуцах                                                       | Алтан-Өлгий оршуулгын газрын арчлалт хамгаалалтыг хариуцах                                                    | Гүйцэтгэлийн хувь       | 100       | 100 | Нийслэлийн төсөв     |

Ес.Хавсралт  
Холбогдох хуулиуд

1. Монгол Улсын үндсэн хууль
2. Монгол Улсын нийслэл улаанбаатар хотын эрхзүйн байдлын тухай хууль
3. Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Хөдөлмөрийн тухай хууль
6. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
7. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
8. Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль
9. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
10. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль